



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/12/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ө.Сийлэгмаа

Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НӨАТТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
НЭМ	Нийгмийн эрүүл мэндийн төв
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17

МАТАД СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Б. ОТГОНТУЯА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Матад сумын сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурьдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Матад сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд хийгдсэн бараа материалын гүйлгээний анхан шатны баримтууд нь бүрдэл дутуу, бараа материалын бүртгэлийг анхан шатны баримтыг үндэслэн /нэр төрөл, тоо хэмжээ, нэг бүрийн үнэ/ орлогодоогүй, багц дүнгээр тайлагнасан, харилцахаас 2 дугаар гарын үсэггүй гүйлгээ хийсэн, хөрөнгө материалын худалдан авалт хийж санхүүжилтийг олгохдоо тооцооны дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэсэн, албан томилолтоор ажилласан хугацааг бичүүлээгүй, томилолтын хуудсыг хаагаагүй, эрх бүхий албан тушаалтны гарын үсэггүй, томилолтын тооцоог бодоогүй, томилолтоор ажиллах тухай дуудсан бичиггүй, унааны баримтгүй, илтгэх хуудасгүй зэрэг нийт 62,465.8мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тооцсон

материаллаг байдлын түвшингээс давж, санхүүгийн тайлангийн бодитой ба тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

Дорнод аймгийн Матад сумын сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Отгонтуяа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 13-наас 2020 оны 02 дугаар сарын 19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 ны 02 дугаар сарын 27 -ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн аудитор Ө.Сийлэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хөдөөгийн хүн амд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай үзүүлэх замаар тэдний амьдралын чанарыг сайжруулах, дундаж наслалтыг уртасгах” гэж тодорхойлсон байна.

Дорнод аймгийн Матад сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй чанартай үзүүлэх салбар хоорондын уялдааг сайжруулах замаар сумын загвар эмнэлгийн хөгжлийг хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Матад сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Матад сумын Эрүүл мэндийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ахрloger программ хангамж ашиглаж байна.

Матад сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөө хангалтгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Матад сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 33 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайланг сонгож, эрсдэлийн түвшингээр дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 374,942.4 мянган төгрөгөөс тооцон 7,498.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин нь 7,498.8 мянган төгрөгөөр тооцогдож төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн чухал үзүүлэлт болох зардлаас материаллаг байдлын түвшин тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,471.8 мянган төгрөгөөр буюу 15 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	9,531.2	33,753.8	24,222.6
Үндсэн хөрөнгө	395,229.1	439,312.9	44,083.8
Хуримтлагдсан элэгдэл	(73,813.7)	(91,648.4)	(17,834.7)
Нийт хөрөнгө	330,946.6	381,418.3	50,471.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	330,946.5	381,418.3	50471.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	330,946.5	381,418.3	50,471.8

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 9,728.6 мянган төгрөгийн эм, 5,353.0 мянган төгрөгийн эд хогшил үнэ төлбөргүй хүлээн авсан, шатахууны 7,071.5 мянган төгрөгийн хүнсний материал, 2,069.5 мянган төгрөгийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 44,083.8 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 6,250.0 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, Сумын хөрөнгө оруулалаар 22,620.1 мянган төгрөгийн халаалтын тогоо, тоног төхөөрөмж, батлагдсан төсвөөс 20,114.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авснаар нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 4,900.3 мянган төгрөгийн акталсан хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 381,418.3 мянган төгрөг болж 50,471.8 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 384,290.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас тусгай зориулалтын шилжүүлгээр 346,423.6 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 26,513.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 11,354.2 мянган төгрөгөөр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 373,722.4 мянган төгрөг буюу 97,3 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас ахмадын болон хүүхдийн сувиллын зардалд 1,300.0 мянган төгрөг, ХӨСҮТ-ээс сүрьеэгийн сорьц тээвэрлэх замын зардалд 158,4 мянган төгрөгийн санхүүжилт олгосон нь нэмэлт дансны орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Эм, хоолны зардалд 1,320.7 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 158.4 мянган төгрөг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 33 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 33 эрсдэл тодорхойлж нийт 33 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 125,998.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 9,728.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,071.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 71,844.3 төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 37,353.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд:

1. Тайлант хугацааны эцэст 7,071.5 мянган төгрөгийн шатахуун /талон / нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 43.5.Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Эмийн худалдан авалтыг тендер зарлаагүй шууд хийсэн бөгөөд Эмийн эргэлтийн сангаас 3,840.0 мянган төгрөгөөр нэмэгдэлтэй үнээр эм нийлүүлсэн нь ТБОНӨХБҮХАТ хуульд нийцэхгүй бөгөөд үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв .

3. Тайлант хугацаанд хийсэн 43,479.9 мянган төгрөгийн худалдан авалтын е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь заалт, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан

шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч е баримтыг хавсаргах” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

4. Тайлант хугацаанд тээвэр шатахуунд 15.2 сая төгрөгийн, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 28.0 сая төгрөгийн төсөв батлагдсан боловч хуулийн дагуу тендер зарлаагүй, харьцуулалт, үнийн судалгаагүйгээр шууд худалдан авалт хийсэн буюу хангалтгүй гэрээ байгуулж ажилласан байгаа нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 48-р зүйл, 49-р зүйл. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэ зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

Аудитын гол асуудал буюу залруулагдаагүй алдаа зөрчил.

Тайлант хугацаанд хийгдсэн бараа материалын гүйлгээний анхан шатны баримтууд нь бүрдэл дутуу, бараа материалын бүртгэлийг анхан шатны баримтыг үндэслэн /нэр төрөл, тоо хэмжээ, нэг бүрийн үнэ/ орлогодоогүй, багц дүнгээр тайлагнасан.

Харилцахаас 24,5 сая төгрөгийн 2 дугаар гарын үсэггүй гүйлгээг төрийн сангаар хийсэн.

Хөрөнгө материалын худалдан авалт хийж санхүүжилтийг олгохдоо тооцооны дансаар дамжуулахгүй шууд зардалд 36,7 сая төгрөг тусгасан байна.

Албан томилолтын тооцоо бодоогүй, хоног бичигдээгүй, томилолтын хуудсыг хаагаагүй, эрх бүхий албан тушаалтны гарын үсэггүй, дуудсан бичиггүй, унааны баримтгүй, илтгэх хуудасгүй зэрэг 1,2 сая төгрөгийн зөрчлүүд нь “Няглан бодох бүртгэлийн тухай” хуулийн 13.7 дахь хэсэгт заасан “ анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” 20,1.4 дэх хэсэгт заасан “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 13.5. Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн бодитой ба тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Матад сумын Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 254.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлснээс албан шаардлагыг хугацаанд нь шийдвэрлэсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Матад сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн аудитын гол асуудалд дурдагдсан залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.4 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн программ нь орон нутгийн өмчийн бүртгэлийн программын маягт гарахгүй байна

2.2. Эрсдэл: Бусад байгууллагуудад өгөх мэдээллийг боловсруулахгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн программд шинэчлэлт хийлгэх

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн Explorer программ нь харилцахаас гүйлгээ хийх үед "Yes" гэдэг сонголт хийж байна. Энэ үйлдэл нь харилцахаас зарлагын гүйлгээ хийхэд түүнийг тооцооны дансаар дамжуулсан мэт харагдуулж шууд зардлын дансанд автоматаар хааж бичдэг. Ингэснээр бараа материалын дансанд орлого авахгүй шууд зардлын дансанд хаах бичилт хийдэг зөрчил зөрчил илэрсэн.

3.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй хураангуй бүртгэл, санхүүгийн тайлан, тодруулга, бусад тайлагналын иж бүрдлийг бүрэн хангахгүй байх, Хөрөнгө хяналтгүй зарцуулагдах, хөрөнгө шамшигдах.

3.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн программд шинэчлэлт хийлгэж

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлнэ

3. *Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал*

4.1 Илрүүлэлт: Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлийн хугацаа дууссан, ашиглагдахгүй байгаа 612.5 мянган төгрөгийн 2 программ хангамжийг данс бүртгэлээс хасаагүй байна.

4.2. Эрсдэл: *Хөрөнгийн үр өгөөж буурах*

4.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, УСНББОУС 17-ын дагуу ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасах

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэ	Эцсийн үлдэгдэ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,531,189.1	33,753,817.3
35	БАРАА МАТЕРИАЛ	9,531,189.1	33,753,817.3
351	Түүхий эд материал	280,500.0	10,009,102.3
35110	Тусгай зориулалттай материал	280,500.0	280,500.0
35130	Эм боох материал	-	9,728,602.3
354	Хангамжийн материал	7,698,689.1	22,192,715.0
35440	Түлш, шатах тослох материал	159,226.2	7,230,712.0
35460	Хүнсний материал	157,904.6	2,330,294.7
35470	Бусад хангамжийн материал	6,992,708.3	12,631,708.3
35600	Мал амьтад	1,552,000.0	1,552,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	321,415,361.5	347,664,464.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	321,415,361.5	347,664,464.9
392	Биет хөрөнгө	303,118,161.5	330,011,153.0
39201	Барилга, байгууламж, орон сууц	264,829,277.4	264,829,277.4
39202	Хуримтлагдсан элэгдэл	(7,523,948.5)	(14,659,416.8)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	39,224,000.0	39,224,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,969,000.0)	(20,909,000.0)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,191,054.3	61,269,074.3
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,710,480.0)	(30,961,333.4)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,035,121.5	25,479,524.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,648,882.2)	(12,287,072.7)
39209	Зам, гүүрийн байгууламж	156,000.0	156,000.0
39210	Хуримтлагдсан элэгдэл	(76,816.6)	(129,899.8)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,483,909.0	30,057,802.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,872,073.3)	(12,057,802.0)
393	Биет бус хөрөнгө	18,297,200.0	17,653,312.0
39303	Бусад биет бус хөрөнгө	18,297,200.0	18,297,200.0
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(643,888.0)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	330,946,550.6	381,418,282.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	330,946,550.6	381,418,282.2
51	Засгийн газрын хувь оролцоо	330,946,550.6	381,418,282.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	374,743,289.0	374,743,289.0
51101	Өмч: - төрийн	374,743,289.0	374,743,289.0
512	Хуримтлагдсан үр дүн	(51,154,451.5)	(682,719.9)
51210	Өмнөх үеийн үр дүн	(51,154,451.5)	(51,154,451.5)
51220	Тайлант үеийн үр дүн	-	50,471,731.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,357,713.1	7,357,713.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	330,946,550.6	381,418,282.2

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	310,546,600.0	426,914,172.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	305,498,200.0	414,080,872.3
120	Нийтлэг татварын бус орлого	-	45,451,602.3
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал		45,451,602.3
121	Хөрөнгийн орлого	-	-
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого		
122	Тусламжийн орлого	33,750,000.0	22,205,670.0
122001	Хандив тусламж /догоод/	33,750,000.0	22,205,670.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	271,748,200.0	346,423,600.0
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	271,748,200.0	346,423,600.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,048,400.0	12,833,300.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,048,400.0	1,479,100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,479,100.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	11,354,200.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	-	11,354,200.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	299,072,255.4	376,442,440.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	299,072,255.4	376,442,440.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	291,350,565.5	370,181,321.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156,484,095.8	219,057,786.0
210101	Үндсэн цалин	135,273,965.8	179,100,086.0
210102	Нэмэгдэл	13,196,768.0	21,396,300.0
210104	Урамшуулал	8,013,362.0	18,561,400.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,682,823.5	30,075,500.0
210201	Тэтгэврийн даатгал	12,861,723.5	20,451,400.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,369,200.0	2,406,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,711,200.0	1,924,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	339,800.0	481,200.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,400,900.0	4,812,100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,049,583.0	5,161,667.0
210301	Гэрэл, цахилгаан	1,589,583.0	1,871,667.0
210302	Түлш, халаалт	6,300,000.0	2,890,000.0
210303	Цэвэр, бохир ус	160,000.0	400,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	15,489,881.8	11,770,728.2
210401	Бичиг хэрэг	409,490.0	1,883,114.0
210402	Тээвэр, шатахуун	13,770,501.8	8,368,314.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	707,500.0	655,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	602,390.0	564,300.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	300,000.0

Дорнод аймгийн Матад сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	30,439,610.7	35,131,809.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,054,947.2	29,118,273.0
210502	Хоол, хүнс	6,952,663.5	4,013,536.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,432,000.0	2,000,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,020,900.0	15,808,015.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,805,000.0	1,840,000.0
210604	Урсгал засвар	3,215,900.0	13,968,015.0
2107	Томилолт, зочны зардал	1,863,400.0	3,000,000.0
210702	Дотоод албан томилолт	1,863,400.0	3,000,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,131,633.8	23,764,419.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж	19,370,606.4	22,922,122.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.0	180,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	371,500.0	375,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	73,333.0	36,500.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.0	88,000.0
210807	Газрын төлбөр	36,194.4	150,297.2
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	12,500.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,188,637.0	26,411,396.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,494,392.8	3,676,500.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,694,244.2	22,734,896.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,721,689.9	6,261,118.8
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,721,689.9	6,261,118.8
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,721,689.9	6,261,118.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	11,474,344.6	50,471,731.6
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	11,474,344.6	50,471,731.6

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	276,796,600.0	381,462,570.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	271,748,200.0	368,629,270.0
122	Тусламжийн орлого	-	22,205,670.0
122001	Хандив тусламж /дотоод/	-	22,205,670.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	271,748,200.0	346,423,600.0
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	271,748,200.0	346,423,600.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,048,400.0	12,833,300.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,048,400.0	1,479,100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,048,400.0	1,479,100.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	11,354,200.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	11,354,200.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	276,796,600.0	381,462,570.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	276,796,600.0	381,462,570.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	269,074,910.1	375,201,451.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156,484,095.8	219,057,786.0
210101	Үндсэн цалин	135,273,965.8	179,100,086.0
210102	Нэмэгдэл	13,196,768.0	21,396,300.0
210104	Урамшуулал	8,013,362.0	18,561,400.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,682,823.5	30,075,500.0
210201	Тэтгэврийн даатгал	12,861,723.5	20,451,400.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,369,200.0	2,406,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,711,200.0	1,924,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	339,800.0	481,200.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,400,900.0	4,812,100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,049,583.0	5,161,667.0
210301	Гэрэл, цахилгаан	1,589,583.0	1,871,667.0
210302	Түлш, халаалт	6,300,000.0	2,890,000.0
210303	Цэвэр, бохир ус	160,000.0	400,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,750,448.0	18,453,364.0
210401	Бичиг хэрэг	798,340.0	1,494,264.0
210402	Тээвэр, шатахуун	12,647,818.0	15,439,800.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	707,500.0	655,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	596,790.0	564,300.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	300,000.0
2105	Нормативт зардал	29,597,633.2	37,320,700.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,054,947.2	29,134,773.0
210502	Хоол, хүнс	6,110,686.0	6,185,927.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,432,000.0	2,000,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,020,900.0	31,968,015.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,805,000.0	18,000,000.0
210604	Урсгал засвар	3,215,900.0	13,968,015.0
2107	Томилолт, зочны зардал	1,863,400.0	3,000,000.0
210702	Дотоод албан томилолт	1,863,400.0	3,000,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	20,131,633.8	23,764,419.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,370,606.4	22,922,122.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.0	180,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	371,500.0	375,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	73,333.0	36,500.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.0	88,000.0
210807	Газрын төлбөр	36,194.4	150,297.2
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний	-	12,500.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,494,392.8	6,400,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,494,392.8	6,400,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,721,689.9	6,261,118.8
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,721,689.9	6,261,118.8
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,721,689.9	6,261,118.8

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капита	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/төгрөг/
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	374,743,288.99	7,357,713.10	-51,154,451.46	0.00	330,946,550.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	374,743,288.99	7,357,713.10	-51,154,451.46	0.00	330,946,550.63
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	374,743,288.99	7,357,713.10	-51,154,451.46	0.00	330,946,550.63
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	374,743,288.99	7,357,713.10	-51,154,451.46	0.00	330,946,550.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	374,743,288.99	7,357,713.10	-51,154,451.46	0.00	330,946,550.63
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	50,471,731.60	0.00	50,471,731.60
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	374,743,288.99	7,357,713.10	-682,719.86	0.00	381,418,282.23

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	271,748,200.0	270,405,400.0	384,290,900.0	373,722,351.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	271,748,200.0	270,405,400.0	384,290,900.0	373,722,351.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	271,748,200.0	270,405,400.0	384,290,900.0	373,722,351.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,026,900.0	156,317,109.8	222,804,300.0	219,057,786.0
210101	Үндсэн цалин	135,376,300.0	135,273,965.8	182,846,600.0	179,100,086.0
210102	Нэмэгдэл	13,550,300.0	13,029,782.0	21,396,300.0	21,396,300.0
210104	Урамшуулал	13,100,300.0	8,013,362.0	18,561,400.0	18,561,400.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,510,300.0	19,682,823.5	30,075,500.0	30,075,500.0
210201	Тэтгэврийн даатгал	13,689,200.0	12,861,723.5	20,451,400.0	20,451,400.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,369,200.0	1,369,200.0	2,406,000.0	2,406,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,711,200.0	1,711,200.0	1,924,800.0	1,924,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	339,800.0	339,800.0	481,200.0	481,200.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,400,900.0	3,400,900.0	4,812,100.0	4,812,100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,018,300.0	8,049,583.0	11,354,200.0	5,161,667.0
210301	Гэрэл, цахилгаан	2,557,900.0	1,589,583.0	2,400,000.0	1,871,667.0
210302	Түлш, халаалт	6,300,000.0	6,300,000.0	8,554,200.0	2,890,000.0
210303	Цэвэр, бохир ус	160,400.0	160,000.0	400,000.0	400,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,709,000.0	14,691,048.0	18,401,400.0	18,294,964.0
210401	Бичиг хэрэг	800,000.0	798,340.0	1,500,000.0	1,494,264.0
210402	Тээвэр, шатахуун	12,589,000.0	12,588,418.0	15,281,400.0	15,281,400.0
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	720,000.0	707,500.0	720,000.0	655,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариугал	600,000.0	596,790.0	600,000.0	564,300.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс			300,000.0	300,000.0
2105	Нормативт зардал	26,767,400.0	25,387,686.0	36,000,000.0	36,000,000.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,527,800.0	18,185,000.0	28,000,000.0	28,558,910.0
210502	Хоол, хүнс	5,806,600.0	5,770,686.0	6,000,000.0	5,441,090.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,433,000.0	1,432,000.0	2,000,000.0	2,000,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,545,400.0	10,544,900.0	32,000,000.0	31,968,015.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,805,400.0	7,805,000.0	18,000,000.0	18,000,000.0
210604	Урсгал засвар	2,740,000.0	2,739,900.0	14,000,000.0	13,968,015.0
2107	Томилолт, зочны зардал	1,865,200.0	1,863,400.0	3,000,000.0	3,000,000.0
210702	Дотоод албан томилолт	1,865,200.0	1,863,400.0	3,000,000.0	3,000,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,394,500.0	19,263,619.8	24,255,500.0	23,764,419.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,503,000.0	18,502,592.4	23,107,000.0	22,922,122.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.0	180,000.0	180,000.0	180,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	371,500.0	371,500.0	375,000.0	375,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.0	73,333.0	93,500.0	36,500.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.0	100,000.0	100,000.0	88,000.0
210807	Газрын төлбөр	40,000.0	36,194.4	350,000.0	150,297.2
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	120,000.0	-	50,000.0	12,500.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,911,200.0	6,883,540.0	6,400,000.0	6,400,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,911,200.0	6,883,540.0	6,400,000.0	6,400,000.0